

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А-172515 дугаар албан бичгийн хоёрдугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНД БАРИМТЛАХ БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

МУИХ-ын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"

(2025 оны жилийн эцсийн байдлаар)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

2025-12-19

Улаанбаатар хот

Д/д	Тэргүүлэх чиглэл	Зорилго	Зорилт	Биелэлт / Биелэлтийн хувь	Тэргүүлэх чиглэлийн дундаж	Зорилгын дундаж
Нэг. Эдийн засгийн бодлого						
ТӨБЭГ - ХЭЗХ, ТӨУЗХ						
	1.3. Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулна.	1.3.2. Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд:	1.3.2.7. Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлж, төрийн болон орон нутгийн өмчит компани болон компанийн нэгдэл хэлбэрээр ажилладаг төрийн өмчит компанийн үйл ажиллагааг уялдуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, шаардлагатай зарим компанийг олон улсын менежментийн багаар	Дэлхийн банкны техникийн зөвлөмжийн дагуу Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газруудын өмчлөлийн хэлбэр, засаглалыг сайжруулах загвар төслийн хүрээнд компанийн засаглалын талаарх олон улсын сайн туршлагыг Монгол улсын өнөөгийн нийгэм эдийн засгийн онцлогт нийцүүлэх байдлаар боловсруулсан. Үүнд, манай улс төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газруудыг төвлөрсөн, нэгдмэл удирдлагаар хангах байдлаар хэрэгжүүлэх нь оновчтой гэж үзсэн. Үүний үр дүнд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын хараат бус байдлыг хангах, сонгон шалгаруулалт нээлттэй болж мэргэжлийн удирдлагаар	90	

<p>удирдуулж, нээлттэй хувьцаат болгон, үр ашиг, тэгш нэмэгдүүлнэ.</p> <p>компани баялгийн хуваарилалтыг</p>	<p>хангах, гэрээний үр дүнг дүгнэх нээлттэй системийг нэвтрүүлэх, хяналт, шалгалтын оновчтой тогтолцоо бүрдэх, олон нийтэд ил тод нээлттэй тайлагналын нэгдсэн механизм бий болж сайн засаглалтай болно. Мөн санхүү, төсвийн сахилга бат сайжрах, хөрөнгө оруулалт, хөрөнгийн менежментийг оновчтой хийх нөхцөл бүрдэх юм.</p> <p>Стратегийн ач холбогдолтой болон бусад томоохон төрийн өмчийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, үнэ цэн бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нийлүүлэх замаар өгөөжийг өсгөх, Үндэсний баялгийн санг бүрдүүлэн Монгол Улсын эдийн засагт хувь нэмэр оруулах зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасан уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын бүх төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд буюу стратегийн ордод үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит нийт 31 компани (16 толгой, 15 охин, хараат)-ийг “Эрдэнэс Монгол” ХХК-д нэгтгэж, нэгдлийн зарчмаар ажиллуулж, Үндэсний баялгийн сангийн орлого төвлөрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлээд байна.</p> <p>Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад харьяалж буй төрийн өмчит үйлдвэрийн газрууд болон “Эрдэнэс Монгол” нэгдлээс бусад төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудыг төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор захиргаа хүний нөөц, санхүү, олон нийттэй харилцах, маркетинг болон үнэлгээ, мониторинг, гадаад харилцаа зэрэг ижил төрлийн зарим үүргийг нэгтгэж, зардал бууруулах, нэгдсэн менежмент хэрэгжүүлж, хяналт тавих үүрэг бүхий “Эрчист Монгол” ХХК-ийг Засгийн газрын 2025 оны 04 дүгээр тогтоолоор байгуулж, зам, тээвэр, хөдөө аж ахуй, санхүү, эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулж буй 44 төрийн өмчит компанийг харьяалуулж, нэгдлийн хэлбэрээр ажиллуулж байна.</p> <p>Төрийн өмчит компаниудад бүтцийн өөрчлөлт хийх, өөрчлөн зохион байгуулах, чиг үүргийн давхардлыг арилгах</p>
--	---

- ажлыг үе шаттай зохион байгуулан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлийг харгалзан бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах асуудлыг судалж, салбарын яамтай хамтран дараах компани, үйлдвэрийн газруудыг нэгтгэх, татан буулгах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн бөгөөд хэрэгжилтийг ханган зохион байгуулалтын арга хэмжээг аван ажиллаж байна. Үүнд:
1. "Баруун бүсийн эрчим хүчний систем" ТӨХК, "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийг "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-д нэгтгэх;
 2. "Богдын голын усан цахилгаан станц" ХХК, "Тосонцэнгэлийн усан цахилгаан станц" ХХК, "Тайшир-Гуулингийн усан цахилгаан станц" ХХК-ийг нэгтгэх.;
 3. Алтай-Улиастай Завхан салбар болон бусад түгээх сүлжээний салбаруудыг нийлүүлж, "Алтай-Улиастайн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК болгох;
 4. "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ-ыг "Эрчис Ойл" ХХК-д нэгтгэх;
 5. "Монгол-Кувейтын байгаль хамгаалах төв" ТӨААТҮГ-ыг "Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв" ТӨААТҮГ-т нэгтгэн зохион байгуулах;
 6. "Монголын үнэт цаасны клирингийн төв" ХХК-ийг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-д нэгтгэн зохион байгуулах;
 7. "Аялал жуулчлалын хөгжлийн төв" ТӨААТҮГ-ыг татан буулгах.

Засгийн газрын 2025 оны "Төрийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 285 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд төрийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн шаардлагатай арга хэмжээг үе шаттай авч байна. Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 30 дугаар хуралдаанаар хэлэлцээд

<p>нээлттэй худалдах арга хэмжээг хэрэгжүүлэх</p>																																																		

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭЖИЛТИЙН
БАЙДАЛТАЙ ХОЛБОТОН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ, ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл", Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоолоор "Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл" баталж, холбогдох зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан бөгөөд бүрэн хэрэгжээгүй болно.

"Төрийн банк" ХК нь нийт хувьцааныхаа 5.71 хувийг, "Монголын хөрөнгийн бирж" ХК нь нийт хувьцааныхаа 34 хувийг тус тус олон нийтэд нээлттэй арилжиж, анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсон.

УИХ, ЗГ-ын дээр дурдсан тогтоолуудад тусгагдсан бусад компанийн нийт хувьцааны 34 хүртэл хувийг нээлттэй арилжаалах үйл явц Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56.2, 56.5-д орсон өөрчлөлт болон тодорхой судалгаагүй, төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны онцлог зэргийг харгалзахгүйгээр зөвхөн И-балагст үндэслэн шийдвэр гаргасан зэрэг нь хөрөнгийн биржээр олон нийтэд арилжаах үйл ажиллагааг үргэлжлүүлэх боломжгүй болгосон.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлд "хувьцааг биржээр арилжих үйл ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан журмын дагуу явуулна" гэж хуульчлалсан бөгөөд системийн банкны нэмэлт хувьцаа гарган IPO хийх ажлыг амжилттай явуулах хүрээнд 2022 онд тус хуульд "56.5.Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт энэ хуульд заасны дагуу нээлттэй хувьцааг компанийн болон төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29-д заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно" гэсэн өөрчлөлтийг төрийн өмчит нийт хуулийн этгээдэд хамааруулан оруулсан нь хөрөнгө оруулагчдыг хязгаарлаж, IPO амжилтгүй болох нөхцлийг бүрдүүлдсэн төдийгүй улмаар төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл хэрэгжихгүй болох нөхцөл байдлыг үүсгэсэн.

Иймд төрийн мэдлийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдахдаа тодорхой судалгаа, төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны онцлог зэргийг харгалзан эрэмбэлэх, системийн банкны нэмэлт хувьцаа гарган IPO хийх ажлыг амжилттай явуулах хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд оруулсан өөрчлөлтийг хүчингүй болгох, холбогдох хуулийн шинэчлэл хийгдэж, эрх зүйн орчныг боловсронгуй болгосны дараа авч үзэхээр хүлээгдэж байна.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон Нийтийн өмчийн хуулийн төсөлд холбогдох эрх зүйн зохицуулалтыг тодорхой, боловсронгуй болгоход чиглэсэн зохицуулалт тусгагдсан.

Монгол Улсын Засгийн газраас Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Нийтийн өмчийн хуулийн төслийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр тус тус Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхээр Эдийн засгийн Байнгын хорооны дэргэд ажлыг хэсэгт байгуулан ажиглалтуулж, анхны хэлэлцүүлэгт оролцож байна.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОЛЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

